



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох,  
сонсгол даргалагчийг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшигчийг тогтоохын үндэслэлээсээний холбогдуулан нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулахаар товлосугай.

2. Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатыг томилсугай.

3. Нэр дэвшигчийн сонсголын талаар нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж, холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо (Л.Энхнасан), мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар (Б.Баасандорж)-т тус тус даалгасугай.

НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

